

МОНГОЛ ДАХЬ ГЭР БҮЛИЙН СУДАЛГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Д.Тунгалаг - МУИС-ийн философийн тэнхмийн профессор

Түлхүүр үг: секс судлал, нийгэм-сэтгэл зүй, хүйс, өрх гэр, уламжлал, хүмүүжил, системт хандлага

1980-аад он хүртэл манай улсад гэр бүлийн судалгаа нь бие даасан байдлаар бус түүх, угсаатан судлал, сурган хүмүүжүүлэх, анагаах ухаан, биологи зэрэг байгаль, нийгмийн шинжлэх ухаануудын судалгаанд хавсрага шинжтэй хөгжиж иржээ. Энэ нь нэг талаар, гэр бүлийн харилцааг хувийн хэрэг хэмээн үздэг субъектив хандлага давамгайлж байсантай, нөгөө талаар гэр бүл-нийгмийн холбооны ач холбогдолыг дутуу үнэлж ирсэнтэй холбоотой гэж үзэж байна. Түүнчлэн гэр бүлийг шинжлэх ухааны судалгааны объект гэж үздэггүй байсан төдийгүй гэр бүлийн дотоод зөрчил, гэр бүл салалтыг улсын нууцад хамруулан хаалттай сэдэв хэмээн үздэг байсан үзэл сурталжсан үзэл санаатай холбоотойгоор уг асуудал судлагдахгүй байсан нь сэдвийн ач холбогдлын талаарх үнэлэмж буурах үндэс болж байжээ.

Манай орон нүүдлийн мал аж ахуйгаас суурьшмал амьдралд, улмаар зах зээлийн эдийн засагт шилжсэн урт удаан хөгжлийн үйл явцад улс орны нийгэм эдийн засагт гарсан өөрчлөлтүүд нь гэр бүлийн амьдралд нөлөөлж эерэг, сөрөг олон үр дагаварыг бий болгосон. Энэ нь судлаач эрдэмтэдийн анхаарлыг татаж, гэр бүлийн амьдралын өөрчлөлтийн учир шалтгаан, гэр бүлийн амьдралд нөлөөлж буй нийгэм, эдийн засаг, оюун санаа, сэтгэл зүйн хүчин зүйлүүдийн шалтгааныг шинжлэх ухааны үүднээс судлах, гэр бүлийн асуудлаар бие даасан судалгаа хийх эхлэл тавигдсан байна.

1980-аад оны дунд үеэс судлаач Д.Болдцэрэн анагаах ухааны чиглэлээр, Д.Тунгалаг философи-ёс зүйн чиглэлээр, Ц.Хурцбилэг социологийн чиглэлээр гэр бүлийн судалгааны ажлыг эхэлсэн бол, 1990-ээд оноос Т.Намжил түүхийн чиглэлээр судалгаа явуулж олон жилийн судалгааныхаа үр дүнгээр анхны бие даасан бүтээлүүдийг¹ тууриажээ. Хэдийгээр эдгээр судлаачид гэр бүлийн асуудлыг тодорхой салбарын хүрээнд судлахдаа тавьсан зорилго, судалгааны арга, шийдвэрлэсэн байдал нь өөр өөр боловч Монголд гэр бүл судлалыг шинээр хөгжүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэсэн юм. Иймээс монгол дахь гэр бүлийн судалгааны анхны бүтээлүүд, энэ чиглэлээр судалгаа хийсэн анхны эрдэмтэн судлаачдын зарим үзэл санаа, онцлог талуудыг гаргах нь гэр бүл судлалыг хөгжүүлэх, гэр бүлийн асуудлаар үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд тус дөхөм болно гэж үзлээ.

¹ Д.Болдцэрэн. Секс судлалын үндэс. Тэргүүн дэвтэр. Дэд дэвтэр. УБ. 1994. Д.Тунгалаг. Гэр бүлийн ёс суртахууны үнэлэмж, өөрчлөлт хувьсал. УБ. 1998. Д.Тунгалаг. Гэр бүлийн ёс суртахуун. УБ. 2000.

Судлаач Д.Болдцэрэн 1980-аад оны дунд үеэс гэр бүлийн харилцаан дахь сексийн асуудлыг судалсан нь монголын гэр бүлийн судалгааны анхны бие даасан судалгаа байсан төдийгүй гэр бүл судлалын үндсийг тавьсан гэж үзэж болно. Тэрээр олон аймаг, хот суурин газруудаар явж социологийн судалгаа хийсний зэрэгцээ анагаах ухаанаас гадна нийгэм, хүмүүнлэгийн ном бүтээлүүдтэй танилцаж "Секс судлалын үндэс" хэмээх хоёр боть номыг тууриулав. Уг бүтээлдээ Д.Болдцэрэн "аливаа юмс үзэгдлийг, түүний дотор секс хэмээх биологи, нийгэм, сэтгэл зүйн маш нарийн үйл явцыг түүхэн болоод бусад юмс үзэгдэлтэй нь нягт холбон үзэхгүйгээр хөгжлийнх нь жинхэнэ мөн чанарыг үнэн бодитой нээн үзүүлэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, тухайн юмс үзэгдэл хэрхэн үүссэн, хөгжлийнхөө явцад ямар ямар үе шатыг туулж өнгөрүүлсэн, мөн чанар нь юу байв гэдгийг анхаарах хэрэгтэй. Иймээс сексийн мөн чанар, сексийн амьдралын нийгэм-сэтгэл зүйн ач холбогдлыг нягтлан үзэж танин мэдэх нь гэр бүлийн амьдралын тогтвор суурьшил, аз жаргалыг бий болгоход нөлөөлдөг нэг гол хүчин зүйл юм¹ гэжээ. Ийнхүү тэрээр гэр бүлийн тогтвортой амьдралд сексийн гүйцэтгэх үүрэг, түүний нийгэм сэтгэл зүйн ач холбогдлыг анх удаа гаргаж тавьсан нь сексийг зөвхөн хувь хүмүүсийн харилцааны асуудал гэж үздэг субъектив үзлээс ангижруулахад чухал ач холбогдолтой шинэлэг санаа болсон юм.

Цааш нь Д.Болдцэрэн хүний секс харилцааг нийгэм-соёлоос ангид үзэх боломжгүйн нэгэн адил сексийн онцлогийг мэдэхгүйгээр ...эр, эм хүйсийн ялгаврыг соёл урлагт хэрхэн билэгдэл дүрээр илэрхийлж, хэрхэн билэг тэмдэг болгон сэтгэж байсан онцлогийг ухаарахгүйгээр нийгмийн аж төрөх ёсыг ойлгох аргагүй гэсэн дүгнэлтийг хийжээ. Өөрөөр хэлбэл, нэг талаас, нийгэм соёлын харилцаа эр эм хүйсийн холбоо шүтэлцээг хэрхэн буй болгож, хувьсган өөрчилж байгааг, нөгөө талаас, секс харилцаа ба түүний илрэх тодорхой хэлбэр нь нийгэм-соёлын харилцааны хөгжилд хэрхэн нөлөөлж буй харилцан холбоог танин мэдэхийн чухалыг товойлгож өгсөн. Иймээс тэрээр аливаа ард түмний аж төрөх ёсыг хөдөлмөрийн хүйсийн хуваарь, хүйсийн бэлэгдэл зүй, өрх бүлийн харилцаа, энгэр зөрүүлэх ёс зэргийг харгалзан үзэхгүйгээр судалж болохгүй юм. Ийм ч учраас сексийн асуудал байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухааны аль ч салбарт ямар нэг хэмжээгээр хөндөгдөж байдаг¹ гэжээ.

Ийнхүү монголын анхны сексологч Д.Болдцэрэнгийн судалгааны арга зүйн онцлог нь секс судлалыг байгаль-нийгэм, нийгэм-хүн, хүн-байгаль гэсэн харилцаанд авч үзэн, хүний гарал үүсэл, мөн чанарыг түүхэн зүйн үүднээс түгээмэл холбоо, шүтэлцээнд нь судлаж, түүнийгээ мэдлэг дундын салбар гэсэн сонирхолтой санааг дэвшүүлсэн нь орчин үеийн монголын гэр бүлийн судалгаанд үнэт материал болж байна. Товчоор хэлбэл, секс судлал нь хүний амьдралын оршихуйн үндсийг судлахад чухал хэрэглэгдэхүүн болно.

¹ Мөн тэнд.

² Д.Болдцэрэн. Секс судлалын үндэс. Тэргүүн дэвтэр. УБ. 1994. 18-р тал

Нийгмийн аливаа үзэгдлийн гарал үүслийг ойлгохгүйгээр хөгжлийнх нь мөн чанарыг үнэн бодитой нээн үзүүлэх аргагүй юм. Өнгөцхөн харахад үл ажиглагдам авч үүсэл гаралтайгаа нягт холбоотой байж, нөгөө тусгалыг нь хадгалан байдаг тохиолдол бишгүй бий. Энэ нь секс судлалд шууд хамаарна. Нөгөөтэйгүүр, Д.Болдцэрэнгийн судалгааны ач холбогдол нь секс харилцааг дан ганц түүхэн зүйн үүднээс төдийгүй нийгмийн бусад юмс үзэгдэлтэй холбоотой авч үзсэн явдал бөгөөд секс судлалын хөгжлийн түүхийг нийгмийн хөгжлийн үе шат бүрийн онцлог, тухайн үеийн сэтгэгчдийн үзэл санаанд нь тулгуурлан диалектик арга зүйгээр тайлбарласанд оршино.

Ийнхүү Д.Болдцэрэн секс нь хувь хүн, гэр бүл төдийгүй нийгмийн ач холбогдолтой болохыг үндэслэж, "секс судлал, удам зүйн /генийн/ ухаан хоёр салшгүй холбоотой болохыг онолын хувьд үндэслэж өгсөн. Д.Болдцэрэнгийн үндэслэсэн энэхүү үзэл санаа нь нэгдүгээрт, гэрлэгсэд бие биеийнхээ гарал, угсаа, удам судрыг сайтар судлах, тэдний хүн чанар, оюуны чадамж, удамшлын өвчин, сэтгэцийн байдал, оюуны хомсдол зэргийг танин мэдэх, хоёрдугаарт, тухайн айл өрхийн төдийгүй монгол угсааг цэвэр ариун байлгах, гуравдугаарт, энэхүү үзэл санаа нь цаашдын гэр бүлийн судалгаанд онол, арга зүйн үндэслэл болж байна.

Доктор Т.Намжилийн "Монголчуудын гэр бүлийн хүмүүжлийн уламжлал" /тэргүүн дэвтэр/, "Монгол ба зүүн хойт азийн гэр бүл" /дэд дэвтэр/ хэмээх ном нь гэр бүлийн өв уламжлалын асуудлаар бичсэн бие даасан томоохон бүтээл юм. Монгол ба монгол төрөл хэлтэн ард түмнүүдийн, тухайлбал, Буриад, Өвөрмонгол, Тува, Якут, Солонгос, Японы гэр бүлийн хүмүүжлийн уламжлалаар харьцуулсан түүний судалгаа нь гэр бүлийн судалгааг түүхэн зарчмаар судлан шинжилэхэд ач холбогдол бүхий эрдэм шинжилгээний бүтээл болсон.

Монголчуудын онцлог шинж нь өөрийн уламжлал, зан заншил, үндэсний соёлдоо ойр дотно бөгөөд түүнийгээ оюун санаа, ёс суртахууны эрхэм дээд үнэт зүйл гэж хүндэлдэг явдал юм. Иймээс Т.Намжил монголын өрх гэрийн хүмүүжлийн гарвал, онцлогийн талаарх асуудлыг нүүдлийн мал аж ахуйн үүсэл, хөгжлийн үйл явцтай холбон тайлбарласан байна. Гэр бүлийн уламжлалын талаарх Т.Намжилийн судалгааны онцлог нь Их гэр бүл хот айлын хүрээнд авч үзсэн явдал бөгөөд тэрээр гэр бүлийн сургах ёсны уламжлалыг "бидний өвөг дээдсийн үр хүүхдээ хүн болгон төлөвшүүлэхэд хуримтлуулсан туршлагыг үеэс үед дамжуулсан хэрэгсэл"¹ гэж дүгнэсэн байна.

Мөн монголчуудын өрх гэрийн хүмүүжлийн уламжлал нь сурган хүмүүжүүлэх мэдлэгийн тодорхой төвшин хийгээд түүхэн тодорхой үеийг тусгаснаараа ардын сурган хүмүүжүүлэх ухааны үүссэн үндэс суурь болсны зэрэгцээ аж ахуйн онцлог шинж, түүний бодит шаардлага, тэрчлэн эл аж ахуйн байгальд зохицсон чанар, өрх гэрийн хүмүүжлийн хөгжил үлэмж нөлөөлж ирсэн нь өрх гэрийн хүмүүжлийн уламжлалын онцлогийг тодорхойлох чиглэлтэй байжээ гэж үзжээ.

¹ Т.Намжил. Монголчуудын гэр бүлийн хүмүүжлийн уламжлал. Тэргүүн дэвтэр. УБ. 1996. 161 дэх тал.

Тэрээр монголчуудын гэр бүлийн хүмүүжил нь гарвалаараа тэдний эрт цагаас эрхэлж ирсэн аж ахуйн хэвшил, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас сурвалжтай болохыг харуулжээ.

Т.Намжилийн судалгаанд хүүхдээ сургах ёсыг уламжлалын нэг гол асуудал болгон авч үзсэн байна. Өрх гэрийн сургах ёсны зорилго нь хүүхдээ амьдралд бэлтгэх явдал байв. Үүнээс үндэслэн үр хүүхдийг амьдрах арга ухаанд суралцахад хэрэгтэй мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэх зорилт гарч иржээ. Иймээс тэрээр “үндэсний дэвшилт уламжлал, зан заншил нь хүмүүжлийн нэн хүчтэй бөгөөд үйлдэлд нөлөөтэй хэрэгсэл мөн” гэж үзсэн байна.

Т.Намжилийн судалгаанд томоохон байр суурь эзэлдэг зүйл бол ураг төрлөө мэдэх, угийн бичгийг хөтлөх явдал байв. Өвөг дээдсийнхээ амьдралын тухай мэдэж байх нь хүүхэд уг язгуураа гээхгүй, эцэг эх, өвөг дээдсээрээ бахархдаг байхад хэрэгтэй. Ийм замаар үе үеийнхний хооронд хэлхээ холбоо тогтооно. Үе үеийнхний хооронд хэлхээ тасарвал уламжлал алдагдан, өв уламжлан залгамжлах тогтолцоо, соёл-түүхийн туршлага алдагдахад хүрнэ хэмээжээ. Иймээс угийн бичиг хөтлөх нь: 1. Гал голомт, өмч хөрөнгө, эд агуурсаа өв болгох, хэндээ уламжлуулахыг тогтоох, 2. Хүмүүсийн хоорондын харилцаанд бол ах зах хүнээ хүндлэх, 3. Нийгэмд овог аймаг, улс үндэстний гарал, утга бичгийн соёлын түүхийг шинжлэн судлах хэрэглэгдэхүүн болдог ач холбогдолтой гэж үзсэн байна. Уг бүтээлдээ Т.Намжил гэр бүлийн хүрээнд үр хүүхдийг амьдралд бэлтгэх, эцэг эхээ хүндлэх ёсонд сургах, хөдөлмөрт сургах, оюун ухааныг нь хөгжүүлдэг уламжлалын асуудлыг нарийвчлан авч үзжээ.

Залуу эрдэмтэн, судлаач Т.Бүрэнжаргалын “Гэр бүлийн социологи” хэмээх ном нь онол, арга зүйн үндэслэл бүхий, гэр бүлийн талаарх түүхэн болон орчин үеийн үзэл баримтлалыг гаргаж тавьснаараа онцлогтой. Т.Бүрэнжаргал гэр бүлийн социологийн судалгааны арга зүйн асуудлыг ерөнхий социологийн судалгааны аргад тулгуурлан авч үзжээ. Ийм ч учраас тэрээр гэр бүлийг судлах системт хандлагын давуу талыг хэд хэдэн зүйлээр тайлбарласан байна.

Тэрээр гэр бүлийг макрообъект буюу нийгмийн институт, микрообъект буюу нийгмийн жижиг бүлэг гэсэн хоёр үндсэн чиглэлээр ангилжээ. “Гэр бүлийг нийгмийн институт болохынх нь хувьд түүнийг түүхэн тодорхой цаг хугацаанд нийгмийн бусад тогтолцоо, нийтлэгтэй хэрхэн харилцан холбогдож” байдаг болохыг авч үзэн, “гэр бүлийг жижиг бүлэг болохын хувьд гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаа холбоог анхааран шинжилж, гэр бүлийн дотоод бүтэц, үүргийн хуваарилалт, гэр бүл салах сэдэл шалтгаан, эхнэр нөхрийн харилцааны шинж чанар, эцэг эх, үр хүүхдүүдийн харилцааны хүрээнд¹ асуудлыг авч үзжээ. Тэрээр оросын эрдэмтэн М.С.Мацковскийн гэр бүлийг нийгмийн системийн бүрдүүлэгч хэсгүүдийн хүчин зүйлтэй нь харьцуулсан

¹ Т.Бүрэнжаргал. Гэр бүлийн социологи. УБ. 2005 он. 11-12-р тал

харьцуулалтад тулгуурлан социологийн системт хандлагын үүднээс анх удаа гэр бүлийн оршин тогтнох нөхцлийг тодорхойлох системийн шинжилгээг хийжээ. Энэ нь гэр бүлийн бүтэц, үүрэг, гадаад дотоод харилцаа холбоо, өөрөөр хэлбэл, хүн – нийгэм - гэр бүлийн харилцааг цогц байдлаар, системтэй судлахад арга зүйн ач холбогдолтой юм.

Доктор Х.Гүндсамбуугийн нийгмийн давхраажилтын судалгаанд² гэрлэлт, гэр бүлийн асуудал томоохон байр суурь эзэлдэг. Тэрээр гэрлэлт ба айл гэр бол монголын нийгмийн давхраажилтыг микро түвшинд тодорхойлохуйц нэгдэх хүчин зүйл мөн гэж үзсэн. Алив хүмүүний нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг давхраажлын тодорхойлох муж нь нэг бол төрөлх гэр бүлээс эсхүл гэрлэлтээс, мөн хожуулангаас нь үлэмж хамааралтай. Зарим нэг хүн хэний гэрт мэндэлснээсээ, зарим нь хэнтэй гэрэлснээсээ, хэнтэй худ ураг болсноосоо хамааран давхраажлын шатаар өгсөж урууддаг гэсэн сонирхолтой санааг дэвшүүлсэн. Ялангуяа эмэгтэйчүүдийн хувь заяанд гэрлэлт онцгой учир холбогдолтой болохыг дурьдаад “ерөөсөө монголчууд сүй тавих, гэрлэх, өрх тусгаарлах, аж төрөхдөө нарийн чанд дэг горимтой, түүхэн уламжлалтай явсан ард түмэн... айл гэрт зарчмын ач холбогдол өгч адаглаад үр удмаа үлдээх, цаашилбал гэрлэлт, ураг төрөлдөө дөрөөлөн нийгмийн байдал, зэрэг зиндаагаа өөрчлөх, ахиулах, хадгалах нь бишгүй” гэжээ. Х.Гүндсамбуугийн энэ дүгнэлтээс үзвэл, гэрлэлт нь хувь хүний нийгэмд эзлэх байр суурь, амьдралын хэтийн чиг хандлагыг тодорхойлох нэг хүчин зүйл болдог гэж ойлгож болох юм.

Тэрээр цааш нь монголчуудын эрт үеэсээ цус холилдох, төрөл ойртохоос сэргийлж бэр буулгах, хүргэн талбихдаа баримталж ирсэн нарийн дэг, хорио цээр алдагдаж ирсэнд шүүмжлэлтэй ханджээ. Манж чин улсын манайханд тулгасан хүн ам зүйн нэгэн бодлого нь овгоо хэрэглэх, угийн бичгээ хөтлөхийг хориглосноос улс төрийн эрхшээл, нөлөөллөө хадгалах зорилгоор гүнжүүдээ язгууртны хүүхдүүдэд өгч, эфү хүргэцүүлийг бий болгож тэднийг хөхүүлэн дэмжиж ирснээс үүдэлтэй болохыг онцлон тэмдэглээд хожим нь нэг талдаа ардын хувьсгалын жилүүдэд зөвлөлтөд эхлээд эрэгтэйчүүдийг, сүүлд нь эмэгтэйчүүдийг сургах болсон, үндэсний сургууль, соёлоор суралцагсад нэмэгдсэн, нөгөө талдаа захиргаадалтын тогтолцоо гүнзгийрч, паспортын дэг журам чангарснаас хүн амын шилжих хөдөлгөөн хумигдаж, хот суурин газрын гэрлэлт задгай, чөлөөтэйдүү, орон нутаг дахь гэрлэлт явцуудуу болсонд шүүмжлэлтэй хансан байна. Түүний энэ шүүмжлэлт үзэл санаа нь гэрлэлт, гэр бүлийн асуудалд хандах төрийн бодлого зайлшгүй шаардлагатай болохыг харуулсан үнэтэй санаа юм.

Х.Гүндсамбуу цааш нь гэрлэлт нийгмийн бүлэг, давхрааны шинжтэй болж, гэрлэлтийн хэм хэмжээ, үнэлэмж өөрчлөгдөж байгааг дурьдаад “гэрлэлт гэр бүлдээ дөрөөлөн нийгмийн давхраажлын шатаар өгсөж уруудагчид зөндөө байсан, одоо ч тэр уламжлал, жишиг ханш тасраагүй, улам ч нарийсаж” буйг

² Х.Гүндсамбуу. Монголын нийгмийн давхраажилт, хөгжил, хандлага. УБ. 2002 он.

анхааралтай авч үзжээ. Энэ шүүмжлэлийн бодит үнэнийг өнөөгийн гэрлэлтэд бий болсон шинэ хандлага, өмч хөрөнгө харгалзан гэрлэх болсон, цус холилдох явдал нэмэгдэж байгаагаас харж болно гэжээ.

2007 онд хуульч Ц.Алтанцэцэг олон жилийн сургалт, судалгааны материалдаа тулгуурлан "Гэр бүлийн эрх зүй" номыг нийтлүүлсэн нь хуульч мэргэжлийн төдийгүй бүх нийтийн гэр бүлийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чухал гарын авлага болсноороо орчин үеийн гэр бүл судлалд тодорхой хувь нэмэр оруулсан гэж үзэж байна. Тэрээр энэ бүтээлдээ хүмүүс өөрсдийн хууль ёсны эрх ашиг, сонирголоо хамгаалах, эрхээ хэрэгжүүлэн, үүргээ гүйцэтгэхийн тулд нэн түрүүнд гэр бүлийн харилцааны эрх зүйн зохицуулалтын талаар зохих мэдлэгтэй байх зайлшгүй шаардлагатай болохыг, гэр бүл нь эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн нэгэн бүлэг болохыг харуулжээ.

Энэ бүхнээс үзвэл, гэр бүл нь нийгмийн олон талт үзэгдлийг бичил хэлбэрээр өөртөө багтаасан байдаг нэгдмэл шинжийг агуулдаг учир гэр бүлийг шинжлэх ухааны аль нэг салбар бүрэн төгс судлах боломжгүй бөгөөд хэсэгчилсэн судалгааны уялдаа холбоог сайжруулах, гэр бүлийг цогц байдлаар судлах, асуудлыг цогц байдлаар авч үзэх нь онолын төдийгүй практик ач холбогдолтой юм.

SUMMARY

Throughout the long term development of Mongolia, many changes happening in the society and it bring effect to family life both negatively and positively. Thus researchers have been taking it into account and scientifically exploring social, economical and psychological factors those causes' family issues. In this article I emphasized main features of research works of researchers B. Boldtsereen, Ts.Hurts who established independent research on family studies and researchers T.Namjil, T.Burenjargal, TS.Altantsetseg who work on history, sociology and legal studies.

Ашигласан ном

1. Д.Болдцэрэн. Секс судлалын үндэс. Тэргүүн дэвтэр. УБ., 1994
2. Д.Болдцэрэн. Секс судлалын үндэс. Дэд дэвтэр. УБ., 1994
3. Д.Тунгалаг. Гэр бүлийн ёс суртахууны үнэлэмж, өөрчлөлт хувьсал. УБ. 1998
4. Д.Тунгалаг. Гэр бүлийн ёс суртахуун. УБ., 2000
5. Т.Намжил. Монголчуудын гэр бүлийн хүмүүжлийн уламжлал. Тэргүүн дэвтэр. УБ., 1996
6. Т.Бүрэнжаргал. Гэр бүлийн социологи. УБ., 2005
7. Х.Гүндсамбуу. Монголын нийгмийн давхраажилт, хөгжил, хандлага. УБ. 2002